



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 439

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 8,466,120.00 (найман сая дөрвөн зуун жаран зургаан мянга нэг зуун хорин) төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн саягтын хамт Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000888

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
439 дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Нийт гүйлт, км	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Хьюндай террасан 03-24 УБЗ (арал kmhnm81cp2v051717)	131250	2008	8,466,120.00	8,466,120.00	-	4,500,000.00
	Нийт дүн			8,466,120.00 (найман сая дөрвөн зуун жаран зургаан мянга нэг зуун хорин)			4,500,000.00 (дөрвөн сая таваг зун мянган)